



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛС БА
ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ
ХОЛБООТ УЛСЫН ХООРОНД 1971-1975
ОНУУДАД ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААР
ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ 1970 ОНЫ
АРВАН ХОЁРДУГААР САРЫН 28 - НД
БАЙГУУЛСАН ХЭЛЭЛЦЭЭРИЙН НЭМЭЛТ

П Р О Т О К О Л

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар ба Зөвлөлт
Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар нь,
монгол, зөвлөлтийн ард түмний ах дүүгийн найрамдал, хамтын
ажиллагааны харилцааг үндэслэн,

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын хүсэлттэй
холбогдуулан,

дор дурдсан зүйлээр тохиролцов:

Нэгдүгээр зүйл

Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн
газар 1975 онд зөвлөлтийн зохих байгууллагуудаар дамжуулан:

а/ БНМАУ-д алт, цагаан туглага, гянт болд, хайлуур жоншны
геолог хайгуулын нэмэгдэл ажил гүйцэтгэхэд техникийн туслалцаа
үзүүлэх;

б/ Бага - нуурын хүрэн нүүрсний орд газарт геолог хайгуу-



2.

лын ажил гүйцэтгэн, өндрийн агаарын зураглалын ажлыг үргэлжлүүлэн хийх ба мөн БНМАУ-д Өмнөд говийн бүсийн зэс - молибдений районд усны хайгуул ба бүлэгчилсэн геологийн зураглалын ажлыг оролцуулан эрэл - хайгуулын ажлыг явуулахад техникийн туслалцаа үзүүлэх;

в/ Улаанбаатар хотод 10 мянга хүртэл хавтгай дөрвөлжин метр сууцны талбай бүхий / Налайх тосгонд барих 3,2 мянган хавтгай дөрвөлжин метр орон сууцны талбайг оролцуулан / орон сууцны барилга барьж 1975 - 1976 онд ашиглалтанд оруулах, мөн түүнчлэн БНМАУ -д Улаанбаатар хотод 3 мянган хавтгай дөрвөлжин метр сууцны талбай бүхий орон сууцны барилга барихад техникийн туслалцаа үзүүлэх;

Хоёрдугаар зүйл

Энэ Протоколын нэгдүгээр зүйлд дурдсан ажлыг гүйцэтгэх ба мөн түүнчлэн Улаанбаатар хотын тоосгоны заводын өргөтгөлийн нэгдүгээр эзлийг дуусгахтай холбогдон зөвлөлтийн байгууллагаас гарах II сая хүртэл рублийн зардлыг Монголын Тал Монгол - Зөвлөлтийн 1970 оны арван хоёрдугаар сарын 28-ны Хэлэлцээрээр Бүгд Найрамдах Монгол Ард Улсад олгосон зээлээр төлөх болно.

Ингэхдээ БНМАУ ба ЗСБНХУ-ын хоорондын бараа гүйлгээг тэгшитгэхэд зориулагдсан зээлийн хэсэг нь II сая рублиэр багасч, харин үйлдвэр, барилга, геолог хайгуулын ажил явуулахад зориулагдсан зээлийн хэсэг ба орон сууц - нийгэм ахуйд зориулагдсан зээлийн



3.

хэсэг нь 6,5 сая рубль ба 4,5 сая рублиэр тус тус нэмэгдэнэ.

Гуравдугаар зүйл

Энэ Протоколд заасан зүйлийн дагуу Талуудын банк нь энэ Протоколын хоёрдугаар зүйлд дурьдсан зээлийн тооцоог хийх ба дансыг хөтлөх талаар тэдгээрийн хооронд урьд тохиролцсон техникийн журамд зохих өөрчлөлтийг хийнэ.

Дөрөвдүгээр зүйл

Энэ Протоколд дурдаагүй бусад бүх зүйлийг Монгол - Зөвлөлтийн 1970 оны арван хоёрдугаар сарын 28-ны Хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.

Тавдугаар зүйл

Энэ Протокол гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Үүнийг 1974 оны долдугаар сарын "24" - ны өдөр Москва хотноо монгол, орос хэл дээр хоёр эх хувь үйлдэв. Хоёр эх хувь нь адил хүчинтэй болно.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ
АРД УЛСЫН ЭРХ ОЛГОСНООР

ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД
НАЙРАМДАХ ХОЛБООТ УЛСЫН
ЭРХ ОЛГОСНООР